

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/276/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор: П.Батцэцэг Утас: 261628 Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn Аудитор: С.Алтанхуяг Утас: 261628 Цахим хаяг: Altankhuyags@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	20
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	22
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл.....	23
4.2 Материаллаг байдал.....	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	24
4.5.1 Завсрын аудитын талаар.....	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.1 Албан шаардлага.....	26
5.2 Зөвлөмж.....	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЗД	Баянзүрх дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийн хөгжүүлэх сан
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/285

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлж байгаа KAPEX төслийн хүрээнд 2024 онд Сангийн яамнаас хоорондын тооцоогоор буцаан авсан Зөвлөх үйлчилгээний 6 ажлын 84.300.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүйгээр сонгон шалгаруулалт зарлаж, нэр бүхийн 3 байгууллагад гэрээний үндсэн дээр нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжилт олгосон;
- ХХААХҮЯ-ны балансад бүртгэлгүй газруудад 17,897.3 мянган төгрөгийн газрын төлбөр төлсөн;
- ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарсан ч тайлант хугацаанд ЗГ-ын 9 дүгээр байрны ашиглалтын зардалд 266,748.2 мянган төгрөгийн байр ашиглалтын зардал төлсөн;
- Улаанбаатар хотод УИХ-ын чуулган болон Засгийн газрын хуралдаанд оролцох талаар нэг тушаалаар 20,200.0 мянган төгрөгийн дотоод томилолт гаргасан бөгөөд

томилолтын тайлангүй, тооцоо бодсон баримтгүй, томилолтын илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй;

- Баянзүрх дүүрэгт байрлах ажилчдын орон сууц нэртэй байшингийн 2008 онд эзэмших эрхийн гэрчилгээ авсан 203 м.кв, нэгж талбарын 1331401420 дугаартай газрыг яамны данс бүртгэлд тусгаагүй, тус барилга, газрыг ашиглах боломжгүй хэмжээнд хүрсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 67 дугаар зүйлийн 67.1, 67.2, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ази тивийн хүнс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны санаачилга /AFACI/-ын хүрээнд Монгол Улсад зохион байгуулсан “Төв Азийн бүс нутгийн орнуудын сүүний үхрийн аж ахуйг хөгжүүлэх” төслийн хүрээнд 140.000.0 мянган төгрөг /40,000.00 ам.доллар/-ийн тусламж хүлээн авч татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Засгийн Газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бүтцийг шинэчлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн, үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улсын бүртгэлийн Э-2204058302 дугаартай, 8287м.кв газар эзэмших эрх, агуулах, аж ахуйн зориулалттай барилга байгууламжийг нээлттэй дуудлага худалдаагаар 1,109,217.9 мянган төгрөгөөр худалдан борлуулж, Дархан-Уул аймагт албан хэрэгцээний дөрвөн орон сууцыг 801,907.7 мянган төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулж бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,915,118,717.13	2,788,533,994.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,170,587.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	88,170,587.00	-
31210	Төгрөг	88,170,587.00	-
31211	Төрийн сангийн харилцах	88,170,587.00	-
33	АВЛАГА	341,641,500.10	1,170,651,371.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	235,051,428.60	1,077,644,347.00
33500	Бусад авлага	106,590,071.50	93,007,024.00
33510	Байгууллагаас авах авлага	1,225,807.50	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	105,364,264.00	93,007,024.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,485,306,630.03	1,617,882,623.38
35100	Түүхий эд материал	1,221,894,555.83	1,216,348,326.07
35110	Тусгай зориулалттай материал	1,221,894,555.83	1,216,348,326.07
35400	Хангамжийн материал	263,412,074.20	401,534,297.31
35410	Бичиг хэргийн материал	11,259,040.00	8,740,246.00
35420	Аж ахуйн материал	3,142,990.00	3,936,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,301,200.00	14,569,738.00
35440	Түлш, шатах тослох материал	9,307,500.00	11,640.70
35450	Барилгын засварын материал	83,632,100.00	93,638,300.00
35470	Бусад хангамжийн материал	148,769,244.20	280,638,272.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,568,463,259.60	23,882,380,874.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,568,463,259.60	23,882,380,874.77
39200	Биет хөрөнгө	23,133,650,798.87	23,610,499,677.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,497,924,893.97	21,734,809,108.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,380,001,633.15)	(1,607,068,359.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	676,890,000.00	676,890,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(518,380,333.94)	(569,638,333.86)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,770,255,935.22	2,702,017,419.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(620,124,711.42)	(1,081,826,494.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	702,627,239.00	912,885,699.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(218,603,285.03)	(293,996,840.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,250,477,992.00	1,261,109,191.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,415,297.78)	(124,681,713.91)
39300	Биет бус хөрөнгө	434,812,460.73	271,881,197.73
39301	Програм хангамж	696,217,760.50	696,217,760.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(593,601,029.77)	(672,175,292.77)
39303	Бусад биет бус хөрөнгө	332,195,730.00	247,838,730.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	25,483,581,976.73	26,670,914,869.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,686,964.64	893,265,016.31
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,686,964.64	893,265,016.31
41300	Өглөг	11,686,964.64	893,265,016.31
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	686,964.64	85,346.31
41360	Бусад өглөг	11,000,000.00	893,179,670.00
41361	Байгууллагад төлөх өглөг	11,000,000.00	892,631,990.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	547,680.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,471,895,012.09	25,777,649,852.84
51	Засгийн газрын хувь оролцоо	25,471,895,012.09	25,777,649,852.84
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,521,194,220.95	6,521,194,220.95
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,521,194,220.95	6,521,194,220.95
51200	Хуримтлагдсан үр дүн	16,888,824,138.25	17,194,578,979.00
51210	Өмнөх үеийн үр дүн	232,177,670.50	16,885,680,397.23

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	16,656,646,467.75	308,898,581.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,061,876,652.89	2,061,876,652.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	25,483,581,976.73	26,670,914,869.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	30,590,243,214.46	13,265,738,366.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,865,450,025.87	13,265,738,366.80
120	Нийтлэг татварын бус орлого	17,865,450,025.87	1,369,788,712.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,751,000.00	13,366,253.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	670,000.00	452,500.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,081,000.00	12,913,753.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,619,610,810.97	1,255,392,460.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,234,088,214.90	101,029,997.25
122	Тусламжийн орлого	-	11,895,949,654.75
1221	Хандив тусламж /дотоод/	-	11,895,949,654.75
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	10,526,224,454.75
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	10,526,224,454.75
12212	Харъяа төсвийн байгууллагаас төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн орлого	-	1,369,725,200.00
122123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн орлого\	-	1,369,725,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,724,793,188.59	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,861,077,264.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,861,077,264.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	863,715,924.59	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,419,994.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	363,295,930.59	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,026,956,983.41	12,198,236,771.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,026,956,983.41	12,198,236,771.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,097,733,145.99	9,941,309,523.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,764,409,002.84	4,985,853,765.19
210101	Үндсэн цалин	2,699,797,313.72	2,717,789,336.19
210102	Нэмэгдэл	1,038,214,866.16	1,196,132,124.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	658,053,238.39	750,964,304.15
210104	Урамшуулал	368,343,584.57	320,968,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	589,120,092.68	621,642,228.47
210201	Тэтгэврийн даатгалын зардал	403,702,720.55	423,153,134.14
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	47,622,436.97	50,077,619.52
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	23,694,706.02	28,462,817.76
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,930,362.98	23,989,731.44
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	91,169,866.16	95,958,925.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,779,300.00	241,221,702.27
210301	Гэрэл, цахилгаан	55,646,880.00	76,187,300.00
210302	Түлш, халаалт	49,071,740.00	144,466,300.27
210303	Цэвэр, бохир ус	20,094,380.00	2,718,102.00

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	3,966,300.00	17,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	212,874,306.53	190,250,627.31
210401	Бичиг хэрэг	75,312,598.00	61,565,540.00
210402	Тээвэр, шатахуун	55,084,914.00	48,505,837.55
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,928,409.53	66,537,982.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,548,385.00	12,187,146.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	1,454,121.76
2105	Нормативт зардал	3,670,513.20	34,350,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,962,513.20	605,750.00
210502	Хоол, хүнс	708,000.00	33,744,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,047,800.00	57,682,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,315,000.00	-
210602	Тавилга	-	5,808,000.00
210604	Урсгал засвар	164,732,800.00	51,874,900.00
2107	Томилолт, зочны зардал	109,115,173.00	36,623,200.00
210702	Дотоод албан томилолт	109,115,173.00	36,623,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960,149,956.00	536,137,728.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	940,429,767.00	455,884,388.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,476.00	28,898,597.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,300,000.00	25,716,000.00
210807	Газрын төлбөр	4,251,713.00	25,638,743.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,160,567,001.74	3,237,547,021.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,474,873,482.40	2,076,079,094.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	685,693,519.34	1,161,347,927.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,929,223,837.42	2,256,927,248.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	611,837,228.96	849,697,555.94
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	582,399,193.30
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	582,399,193.30
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	243,996,622.70
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	338,402,570.60
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	611,837,228.96	267,298,362.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,758,809,961.64	1,407,229,692.11
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,646,000.00	8,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,260,320,150.00	1,294,305,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	382,388,631.64	99,044,692.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	81,455,180.00	5,880,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	558,576,646.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,335,999.99	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	374,240,646.83	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	17,563,286,231.05	1,067,501,595.64
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	906,639,763.30	758,603,013.87
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	69,022,408.26	667,262,887.47
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	372,437.10	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	837,244,917.94	91,340,126.40
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(906,639,763.30)	(758,603,013.87)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	16,656,646,467.75	308,898,581.77
----	---	-------------------	----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	13,189,980,333.43	12,158,188,373.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,751,000.00	12,158,188,373.35
120	Нийтлэг татварын бус орлого	175,751,000.00	736,308.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,751,000.00	736,308.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	670,000.00	736,308.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,081,000.00	-
122	Тусламжийн орлого	-	12,157,452,065.35
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,157,452,065.35
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	10,526,224,454.75
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	10,526,224,454.75
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,631,227,610.60
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,631,227,610.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,014,229,333.43	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,861,077,264.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,861,077,264.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,153,152,069.43	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,419,994.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	652,732,075.43	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,940,070,625.43	12,167,723,410.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,940,070,625.43	12,167,723,410.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,117,231,406.41	7,166,944,015.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,928,755,875.00	4,930,510,806.48
210101	Үндсэн цалин	2,787,300,444.93	2,549,217,762.76
210102	Нэмэгдэл	1,115,825,465.49	1,310,216,842.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	657,914,838.39	750,550,000.00
210104	Урамшуулал	367,715,126.19	320,526,201.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	589,016,282.88	670,384,912.51
210201	Тэтгэврийн даатгалын зардал	403,617,270.05	458,175,675.21
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	47,671,918.33	54,142,698.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	23,776,220.44	28,473,838.79
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,900,491.97	25,918,539.99
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	91,050,382.09	103,674,159.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,779,300.00	241,221,702.27
210301	Гэрэл, цахилгаан	55,646,880.00	76,187,300.00
210302	Түлш, халаалт	49,071,740.00	144,466,300.27
210303	Цэвэр, бохир ус	20,094,380.00	2,718,102.00
210304	Байрны түрээс	3,966,300.00	17,850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	229,501,502.53	131,910,139.00
210401	Бичиг хэрэг	67,518,760.00	20,039,650.00
210402	Тээвэр, шатахуун	52,875,608.00	22,096,971.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,928,409.53	63,643,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	67,178,725.00	26,129,818.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	194,138,930.00	90,011,801.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,414,680.00	6,931,400.00

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	165,724,250.00	83,080,401.00
2107	Томилолт, зочны зардал	112,783,798.00	39,586,600.00
210702	Дотоод албан томилолт	112,783,798.00	39,586,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,627,624.00	795,359,574.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,314,156,435.00	715,106,234.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,476.00	28,898,597.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,051,000.00	25,716,000.00
210807	Газрын төлбөр	4,251,713.00	25,638,743.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	586,628,094.00	267,958,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	586,628,094.00	267,838,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,822,839,219.02	5,000,779,395.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	611,837,228.96	1,893,701,315.94
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,626,402,953.30
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,626,402,953.30
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	243,996,622.70
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	-
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	338,402,570.60
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,044,003,760.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	611,837,228.96	267,298,362.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,417,373,914.64	3,073,437,492.11
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	34,646,000.00	8,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,916,984,103.00	2,960,512,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	382,388,631.64	99,044,692.11
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	83,355,180.00	5,880,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	793,628,075.42	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,335,999.99	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	609,292,075.43	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	33,640,587.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,640,587.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	249,909,708.00	(9,535,037.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	177,266,588.00	78,635,550.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	177,266,588.00	78,635,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	177,266,588.00	78,635,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	177,266,588.00	78,635,550.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(177,266,588.00)	(78,635,550.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	72,643,120.00	(88,170,587.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,527,467.00	88,170,587.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,170,587.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	232,177,670.50	8,815,248,544.34
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	232,177,670.50	8,815,248,544.34
Тайлант үеийн үр дүн	-	-	16,656,646,467.75	16,656,646,467.75
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	16,888,824,138.25	25,471,895,012.09
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	16,888,824,138.25	25,471,895,012.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,143,741.02)	(3,143,741.02)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	16,885,680,397.23	25,468,751,271.07
Тайлан үеийн үр дүн	-	-	308,898,581.77	308,898,581.77
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,521,194,220.95	2,061,876,652.89	17,194,578,979.00	25,777,649,852.84

/төгрөгөөр/

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

<i>/төгрөгөөр/</i>					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	11,544,537,200.00	10,282,964,140.05	(1,261,573,059.95)	89.1
12	Татварын бус орлого	11,544,537,200.00	10,282,964,140.05	(1,261,573,059.95)	89.1
120	Нийтлэг татварын бус орлого	-	736,308.00	736,308.00	0.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	736,308.00	736,308.00	0.0
122	Тусламжийн орлого	11,544,537,200.00	10,282,227,832.05	(1,262,309,367.95)	89.1
122005	Төсвөөс санхүүжих	11,544,537,200.00	10,282,227,832.05	(1,262,309,367.95)	89.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,544,537,200.00	10,282,964,140.05	(1,261,573,059.95)	89.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,544,537,200.00	10,282,964,140.05	(1,261,573,059.95)	89.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,798,131,100.00	6,946,108,285.30	(852,022,814.70)	89.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,051,855,800.00	4,930,510,806.48	(121,344,993.52)	97.6
210101	Үндсэн цалин	2,591,674,800.00	2,549,217,762.76	(42,457,037.24)	98.4
210102	Нэмэгдэл	1,315,680,100.00	1,310,216,842.22	(5,463,257.78)	99.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	785,567,100.00	750,550,000.00	(35,017,100.00)	95.5
210104	Урамшуулал	358,933,800.00	320,526,201.50	(38,407,598.50)	89.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	697,147,100.00	670,384,912.51	(26,762,187.49)	96.2
210201	Тэтгэврийн даатгал	473,060,000.00	458,175,675.21	(14,884,324.79)	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	55,771,800.00	54,142,698.73	(1,629,101.27)	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,885,900.00	28,473,838.79	(412,061.21)	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	27,885,900.00	25,918,539.99	(1,967,360.01)	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	111,543,500.00	103,674,159.79	(7,869,340.21)	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	410,352,100.00	241,221,702.27	(169,130,397.73)	58.8
210301	Гэрэл, цахилгаан	136,406,100.00	76,187,300.00	(60,218,800.00)	55.9
210302	Түлш, халаалт	198,197,100.00	144,466,300.27	(53,730,799.73)	72.9
210303	Цэвэр, бохир ус	28,299,800.00	2,718,102.00	(25,581,698.00)	9.6
210304	Байрны түрээс	47,449,100.00	17,850,000.00	(29,599,100.00)	37.6
2104	Хангамж, бараа материалын зардал	135,989,900.00	135,989,859.00	(41.00)	100.0
210401	Бичиг хэрэг	23,570,800.00	21,839,650.00	(1,731,150.00)	92.7
210402	Тээвэр, шатахуун	26,487,000.00	22,096,971.00	(4,390,029.00)	83.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,861,600.00	63,643,700.00	5,782,100.00	110.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,070,500.00	28,409,538.00	339,038.00	101.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	116,630,100.00	115,047,631.00	(1,582,469.00)	98.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,982,000.00	18,012,900.00	(969,100.00)	94.9
210602	Тавилга	14,054,300.00	13,954,330.00	(99,970.00)	99.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	-	(450,000.00)	0.0
210604	Урсгал засвар	83,143,800.00	83,080,401.00	(63,399.00)	99.9
2107	Томилголт, зочны зардал	44,800,000.00	39,586,600.00	(5,213,400.00)	88.4
210702	Дотоод албан томилолт	44,800,000.00	39,586,600.00	(5,213,400.00)	88.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,322,986,100.00	795,359,574.04	(527,626,525.96)	60.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,233,228,700.00	715,106,234.00	(518,122,466.00)	58.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,345,200.00	-	(1,345,200.00)	0.0

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	29,657,500.00	28,898,597.04	(758,902.96)	97.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	202,000.00	-	(202,000.00)	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,388,000.00	25,716,000.00	(5,672,000.00)	81.9
210807	Газрын төлбөр	27,164,700.00	25,638,743.00	(1,525,957.00)	94.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,370,000.00	18,007,200.00	(362,800.00)	98.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,000,000.00	17,887,200.00	(112,800.00)	99.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	120,000.00	(250,000.00)	32.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,746,406,100.00	3,336,855,854.75	(409,550,245.25)	89.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	619,084,100.00	267,298,362.64	(351,785,737.36)	43.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	619,084,100.00	267,298,362.64	(351,785,737.36)	43.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,127,322,000.00	3,069,557,492.11	(57,764,507.89)	98.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,000,000.00	8,000,000.00	(12,000,000.00)	40.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,980,012,000.00	2,960,512,800.00	(19,499,200.00)	99.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,045,000.00	99,044,692.11	(307.89)	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,265,000.00	2,000,000.00	(26,265,000.00)	7.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	88,170,587.00	88,170,587.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	298,526,622.70	298,526,622.70	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	106	106	-	100.0
620001	Удирдах ажилтан	17	14	(3)	82.4
620002	Гүйцэтгэх ажилтан	89	92	3	103.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	1,631,227,610.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,631,227,610.60
122	Тусламжийн орлого	-	1,631,227,610.60
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,631,227,610.60
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,631,227,610.60
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,631,227,610.60
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	248,821,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	248,821,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	248,821,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	49,520,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	49,520,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	199,301,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	199,301,280.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		1,382,406,330.60
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(1,382,406,330.60)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(1,382,406,330.60)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг, хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх, түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Яам нь тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэл, дотоод худалдааны урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлох, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Мал аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, мал эмнэлэг, малын үржүүлэг, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, бэлчээр ашиглалтын бодлого, усан хангамж, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа, малчдын хоршооны тогтолцоог хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, богино хугацааны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Газар тариалангийн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа, хөрсний үржил шимийг сайжруулах, ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэх, тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, таримал ургамлыг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх газар тариалангийн салбарын тогтолцоог хөгжүүлэх, богино хугацааны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Хөнгөн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, ноос, ноолуур, арьс, ширийг гүн боловсруулах, импортыг орлох, экспортын баримжаатай сүлжмэл, нэхмэл, оёмол хувцас, арьс, ширэн бүтээгдэхүүн, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдааг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтолцоог хөгжүүлэх, богино хугацааны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Хүн амын эрүүл, баталгаат хоол, хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын тогтолцоог хөгжүүлэх, богино хугацааны арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах,

батлуулах, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;

- Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, байгууллага, салбарын бодлого, үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг, төсвийн тооцоо, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, санхүү, төсвийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллах;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэдээлэл технологи, мэдээлэл солилцоо, нууцлал, аюулгүй байдал болон дижитал дэд бүтцийг нэгдсэн бодлогоор хангах, салбарын нэгдсэн мэдээллийн сангийн удирдлага, хөгжүүлэлт, системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн хөгжүүлэх, салбарын статистик мэдээ гаргах, түгээх, цахим шилжилтэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахим хэлбэрээр хүргэх;
- Мал, амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүсэж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Малчны тухай хууль;
- Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль;
- Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжиж үнийг зохистой түвшинд тогтворжуулах зорилгоор импортоор оруулах мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай;
- Улсын Их Хурлын 2025 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 73 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2025 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 85 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;

- Засгийн Газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоол /Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам/;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 46 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Аян өрнүүлэх тухай" 47 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 47 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 48 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 56 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 66 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Техникийн зохицуулалт шинэчлэн батлах тухай" 69 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоолд нэмэлт оруулах тухай" 78 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 96 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 108 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай" 166 дугаар тогтоол;
- Засгийн Газрын 2025 оны "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай" 190 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,187,332.8 мянган төгрөгөөр буюу 104 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	88,170.6	-	(88,170.6)
Авлага	341,641.5	1,170,651.3	829,009.8
Бараа материал	1,485,306.6	1,617,882.6	132,576.0
Үндсэн хөрөнгө	23,568,463.3	23,882,380.9	313,917.6
Нийт хөрөнгө	25,483,582.0	26,670,914.8	1,187,332.8
Өр төлбөр	11,687.0	893,265.0	881,578.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	25,471,895.0	25,777,649.8	305,754.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	25,483,582.0	26,670,914.8	1,187,332.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 88,170.6 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснээс шалтгаалсан;
- Авлага дансны үлдэгдэл 1,170,651.3 мянган төгрөг болж өмнөх оноос 829,009.8 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлага 1,077,644.3 мянган төгрөгт хүрснээс шалтгаалсан байна. Тус авлагад Дархан-Уул аймагт албан тушаалын 4 орон сууц худалдан авсан 801,907.7 мянган төгрөгийн авлага голлох нөлөө үзүүлсэн. Хувь хүнээс авах авлагын үлдэгдэлд ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон ажилтанд байгууллагын төсвөөс олгосон нөхөн төлбөрийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас авах 93,007.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй, тус авлагад Улсын ерөнхий прокурорын газар дээр ажиллагаа хийгдэж байна;
- Бараа материал дансны үлдэгдэл 1,617,882.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 132,576.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хангамжийн материал 138,122.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны цэвэр үлдэгдэл 23,882,380.9 мянган төгрөг болж 313,917.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал,
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 863,959.5 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авсан;
 - Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төсөл, Тэжээлийн тогтвортой менежментийн төслүүдийн хэрэгжих хугацаа дуусаж 133,878.5 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан;
 - ТӨБЗГ-ын 2025 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 405 дугаар тогтоолоор яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн нийт 754,337.6 мянган төгрөгийн балансын үнэ, 212,875.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулж, шилжүүлсэн;
 - Дархан-Уул аймагт албан хэрэгцээний зориулалтаар дээрх агуулах зарсан мөнгөөр 4 орон сууц 801,997.7 мянган төгрөгөөр авахаар гэрээ байгуулж, дансанд бүртгэсэн;

- Өр төлбөр дансны үлдэгдэл 893,265.0 мянган төгрөг болж өмнөх оноос 881,578.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь албан тушаалын 4 орон сууц Дархан-Уул аймагт худалдан авсан төлбөрийг Сангийн яамнаас Татаас санхүүжилтийн авлагаар тусгаж, 4 иргэнд өглөгөөр тусгаснаас шалтгаалсан;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант оны үр дүн 308,898.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яамны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 12,266,789.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 112,657.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 12,379,446.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлыг 135,712.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 834,909.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг улсын төсвөөс 11,544,537.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 10,526,224.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт байгууллагын өөрийн орлого 736.3 мянган төгрөгийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээний зардалд 6,946,108.3 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 3,336,855.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 243,996.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,282,964.1 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамжийг 351,785.7 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээний зардлыг 527,626.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээний нэр, код		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
70805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	11,544,537.2	10,282,964.2	1,261,573.0	89.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,489,243.1	6,207,402.4	68,271.0	99.0
80102	Туслах үйл ажиллагааны зардал	270,484.6	122,682.5	147,802.1	45.4
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	738,674.9	403,718.1	334,956.4	54.6
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	619,084.1	267,298.4	351,785.7	43.2
80704	Ахмад дайчин, алдар цолтой Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	1,214,212.0	1,201,120.0	13,092.0	98.9

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	147,310.0	109,044.7	38,265.3	74.0
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	299,728.5	212,305.3	87,423.1	70.8
82533	Сайн малчны шагнал	1,765,800.0	1,759,392.8	6,407.1	99.6

Тайлант оны төсөвт байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээний бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,260,393.4 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 740,744.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардалд 18,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 17,887.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төсөл хөтөлбөрийн хүрээнд татаас санхүүжилтийн авлагаар тусгасан 235,051.4 мянган төгрөг, 2013 оны Засгийн газрын 250 дугаар тогтоолын хүрээнд олгогдсон “Дамжуулан зээлдүүлэх” гэрээний биелэлтээс 1,180,143.7 мянган төгрөг, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах агуулах, аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийг дуудлага худалдаагаар борлуулснаас 1,109,217.9 мянган төгрөг, акталсан үндсэн хөрөнгө борлуулсан бусад орлого 3,060.0 мянган төгрөг, Ази тивийн хүнс, хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны санаачлага /AFACI/ санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх төслөөс 257,007.3 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон бусад нэмэлт орлогын эх үүсвэрээс 26,890.9 мянган төгрөг, нийт 2,811,371.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Үүнээс Хөрсний бодлогын зөвлөмж гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулахад 84,300.0 мянган төгрөг, Дамжуулан зээлдүүлэх гэрээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 1,180,143.7 мянган төгрөг, Нууцын зориулалттай өрөөний техник хангамжийн зардалд 49,500.0 мянган төгрөг, Төв азийн бүс нутгийн орнуудын сүүний үхрийн аж ахуйг хөгжүүлэх төслийн уулзалт, хэлцүүлэгт 115,001.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,382,406.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс 1,044,003.7 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Хөдөө аж ахуйн яам, Хөдөлмөрийн яам хооронд байгуулсан 2013 оны 20130716-001, ХЯ-9/2013/02 тоот “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-г үндэслэн сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх оёдлын компаниудад даавуу үйлдвэрлэх болон хонины ноосон ээрмэл утас үйлдвэрлэхэд шаардагдах санхүүжилтэд зориулан олгосон зээлийн эргэн төлөлтөд шүүхийн шийдвэрийн дагуу 1,180,143.7 мянган төгрөгийн орлого төвлөрснийг Хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих санд буцаан төвлөрүүлж ажил, гүйлгээг орлого бууруулан тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ХХААХҮЯамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн А/17 дугаар тушаалаар баталж гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд тусган тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй, тооцоо нийлж баталгаажуулдаг байх, Төрийн хэмнэлтийн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор П.Батцэцэг, Аудитор С.Алтанхуяг, Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02/283 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 13,026,956.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 130,269.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллийг хугацаандаа оруулж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 02/275 дугаар албан бичгээр Шилэн дансны тайлангийн нэгтгэлийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2025 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж 2,368,725.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, баталгаажуулсан. Мөн байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 771,883.7 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага, 263,984.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгснийг 91.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	771,883.7	4	678,876.7	88.0
Зөвлөмж	3	263,984.2	3	263,984.2	100
Нийт дүн	8	1,035,867.9	7	942,860.9	91.0

Өмнөх оны аудитаар өгсөн Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үлдэгдлийг барагдуулах, Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тэмдэглэл, урсгал төсвийн болон нэмэлт санхүүжилтийн тайлан, төсвийн тохируулгын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу иж бүрэн бэлтгэн, толилууль байх зэрэг зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан хаагчид ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 102,653.4 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлснийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй, авлагын үлдэгдэл 93,007.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, Улсын Ерөнхий прокурорын газарт ажиллагаа хийгдэж байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус яамны дараагийн аудитаар анхаарал хандуулах дараах асуудлууд байна. Үүнд:

- Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарч үе шаттайгаар нүүсэн боловч бичиг хэргийн ажилтан болон бодлогын газрын ажилтнууд Улаанбаатар хотод ажиллаж байгаатай холбогдуулан байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахад тодорхой зарим нэг хүндрэл бэрхшээл үүсэж байгааг анхаарах.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь төсвийн сар улирлын хуваарийг албажуулж төсвийн шууд захирагчид хүргүүлдэггүйн улмаас төсөв зөрүүлж тайлагнаж байгаа асуудлыг онцгойлон анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,400.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Бараа материалын тайланд 350,000.00 төгрөгийн үнийн дүнтэй 4 ш дугуйг үнэ, тоо ширхэгийг зөрүүлэн бүртгэсэн нь **УСНББОУС 2** стандарт, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 437,484.6 мянган төгрөгийн 11 зөрчил² илэрснээс, 157,278.5 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 280,206.1 мянган төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 437,484.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 307,215.1 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Дархан-Уул аймгаас Улаанбаатар хотод Улсын Их Хурлын чуулган болон Засгийн газрын хуралдаанд оролцох талаар нэг тушаалаар 20,200.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гаргасан бөгөөд томилолтын тооцоо бодсон баримтгүй, илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйл 20.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод албан томилолтын зардлын тайлан, илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны балансад бүртгэлгүй 9 тээврийн хэрэгслийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 3,273.9 мянган төгрөгийн ногдол гарсныг Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ийн 1 дэх хэсэгт "Өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тус яамны нэр дээр бүртгэлтэй Тээврийн хэрэгслийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Тус яамны баланст бүртгэлтэй 44,655.6 мянган төгрөгийн үнэтэй Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд байрлах ажилчдын орон сууц нэртэй байшингийн /1 давхар, балгас болсон/ 2008 онд эзэмших эрхийн гэрчилгээ авсан 203 м.кв, нэгж талбарын 1331401420 дугаартай газрыг яамны данс бүртгэлд тусгаагүй, тус барилга, газрыг ашиглах боломжгүй хэмжээнд хүрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 14 дүгээр зүйлийн 14.2.2-д "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ийн 1 дэх хэсэгт "Өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус газрыг яамны хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Татварын ерөнхий газрын e-tax цахим системд тус яам 4,849.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн өртэй гарсан бөгөөд газрын төлбөрийн ногдол гарсан Булган, Ховд, Төв аймгуудад байгаа тус яамны нэр дээрх газрын мэдээллүүд тодорхойгүй, татварын алба, газрын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Булган, Ховд, Төв аймгуудад байгаа тус яамны нэр дээрх газрын мэдээллүүдийг тодорхой болгож, газрын төлбөрийн өрийг шийдвэрлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Бүгд найрамдах Солонгос Улсын Хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлж байгаа KAPEX төслийн хүрээнд 2024 онд Сангийн яамнаас хоорондын тооцоогоор буцаан авсан Зөвлөх үйлчилгээний ажлын 84,300.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүйгээр сонгон шалгаруулалт зарлаж, нэр бүхий 3 байгууллагад гэрээний үндсэн дээр 12 дугаар сарын 25-нд нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй ажлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХААХҮС-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/688 дугаар тушаалаар балансаас балансад шилжүүлсэн Хүнсний ногооны үрийн хөнгөлөлтийг Аймаг, нийслэлд хуваарилахдаа бодит тооцоо судалгаанд үндэслэн хуваарилаагүйн улмаас 26,890.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.2.2-т "Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, бодит тооцоо судалгаанд үндэслэн хуваарилалт хийх, нэмэлт санхүүжилтийн дансанд зориулалтын дагуух орлогыг бүрдүүлж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХААХҮЯам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарсан ч тайлант хугацаанд Засгийн Газрын 9 дүгээр байрны ашиглалтын зардалд 266,748.2 мянган төгрөг Дархан-Уул аймгийн ЗДТГ-т ашиглалтын зардалд 336,741.8 мянган төгрөг, нийт 603,490.1 мянган төгрөгийн байр ашиглалтын зардлыг давхардуулан төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", МУЗГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1-д "Төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс" болгон хөгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөн, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт давхардуулан төлж байгаа асуудлыг шийдвэрлэх.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд байрлах, 4563м.кв, 1331401299 нэгж талбарын дугаар бүхий, Хөдөө аж ахуйн машин, механизмын хашаа граж нэртэй эзэмших эрхтэй газрын гэрээг 2025 онд сунгасан боловч, гэрчилгээ, гэрээ байхгүй, балансад бүртгэлгүй, e-gazar цахим системд тус яамны нэр дээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ийн 1 дэх хэсэгт "Өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Egazar.gov.mn цахим системд тус яамны нэр дээр бүртгэлтэй боловч данс бүртгэлд тусгаагүй асуудлыг шийдвэрлэх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянзүрх дүүргийн 3 дугаар хороонд байрлах 975 м.кв, 1330100010 нэгж талбарын дугаартай яамны дансанд бүртгэлтэй газар дээр БШУЯ-ны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд цэцэрлэг баригдаж, 979,348.8 мянган төгрөгийн дансны үнэ бүхий Нийслэлийн 59 дүгээр цэцэрлэг байршиж байна. Тус газрын төлбөрт ХХААХҮЯам тайлант онд 409.5 мянган төгрөгийн газрын төлбөр төлсөн байна.

Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд анх удаа бүртгэхэд газрын нэгж талбарын дугаарт үндэслэх бөгөөд нэг нэгж талбарт нэг хувийн хэрэг нээж, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг уг нэгж талбар газрын эрхтэй нэг бүрдлээр бүртгэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус яамны дансанд бүртгэлтэй уг газрыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлан, үл хөдлөх хөрөнгө, газар тусдаа бүртгэлтэй, газрын төлбөрт жил бүр төлбөр төлж байгаа асуудлыг шийдвэрлүүлэх.

5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хан-Уул дүүрэгт байрлах 3398 м.кв, 1781001787 тоот нэгж талбарын дугаартай яамны нэр дээрх "Үйлчилгээний орон сууц"-ны зориулалттай эзэмших эрхийн газрын гэрчилгээг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/682 тоот захирамжаар 15 жилийн хугацаатай сунгуулсан боловч гэрээг байгуулж баталгаажуулаагүй, газрын төлбөрт тайлант онд 13,048.3 мянган төгрөг төлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ийн 1 дэх хэсэгт "Өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус яамны нэр дээрх боловч данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийн газрын төлбөр төлж буй уг газрыг данс бүртгэлд тусгах.

6. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: МУЗГ-ын 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн "Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай" 250 дугаар тогтоол гарч 23,000,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг сурагчийн дүрэмт хувцасны үйлдвэрлэл эрхлэгчдэд 2013 онд багтаан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хөнгөлөлттэй зээлээр олгохыг Хөдөлмөрийн сайдад зөвшөөрсүгэй гэсэн шийдвэр гарсан. 2013.07.16-ний өдрийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 23,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг /ХЭДС-аас 17,000,000.0 мянган төгрөг, ЖДҮХС-аас 6,000,000.0 мянган төгрөг/ Сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдэд олгох шийдвэр гарч, зээл, зээлийн хүүг эргэн төвлөрүүлэх, зээлийн эрсдэлийг тухайн үеийн нэрээр ҮХААЯам бүрэн хариуцна гэж тус гэрээнд тусгасан байна. Энэхүү гэрээний хүрээнд зээл авсан гэх компаниудаас шүүхийн шийдвэрээр зээлийн эргэн төлөлтөд орж ирсэн 1,180,143.6 мянган төгрөгийг ХЭДСанд тооцоо нийлсэн актгүйгээр төвлөрүүлсэн, тус гэрээнд заасан хамтарсан хяналтын зөвлөл хяналтаа хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Үйлдвэр, Хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 16-ны ХЯ-9/2013/02, ҮХААЯ-20131716 тоот гэрээний 2 дугаар зүйлийн 2.7-д "Зээлийн баталгаа: Зээл, зээлийн хүүг эргэн төвлөрүүлэх, зээлийн эрсдэлийг ҮХААЯ бүрэн хариуцна.", 2.8-д "Зээл олгох ААН-ийг шалгаруулах, зээлийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй Сангийн яам, БШУЯ, ҮХААЯамны хамтарсан хяналтын зөвлөл ажиллана. Хамтарсан хяналтын зөвлөлийг ҮХААЯамны ТНБД даргалж, БШУЯамны төлөөлөл нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ", 4 дүгээр зүйлийн 4.4-т "Төслийн хэрэгжилтийн явцад гарч буй аливаа алдаа зөрчлийг тухай бүрт Сангийн яам, БШУЯам, ҮХААЯамны хамтарсан хяналтын зөвлөлд бичгээр мэдэгдэн шийдвэрлүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх Засгийн Газрын тогтоолын хүрээнд олгосон тус зээлийн төлөгдөөгүй бодит үлдэгдлийг тодорхой болгох, Гэр бүл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай тооцоо нийлж баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл***/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын тайланд 350.000 төгрөгийн үнийн дүнтэй 4 ш дугуйг үнэ тоо ширхэгийг зөрүүлэн бүртгэж тайлагнасан байна.	1	1,400.0			1	1,400.0	1	1,400.0				
Дүн	1	1,400.0	-	-	1	1,400.0	1	1,400.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Улаанбаатар хотод УИХ-ын чуулган болон Засгийн газрын хуралдаанд оролцох талаар нэг тушаалаар 20,200.0 мянган төгрөгийн дотоод томилолт гаргасан бөгөөд томилолтын тайлангүй, тооцоо бодсон баримтгүй, томилолтын илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй зэрэг байна.	1	20,200.0			1	20,200.0							
Тус яамны балансад бүртгэлгүй, 9 тээврийн хэрэгслийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 3,273.9 мянган төгрөгийн ногдол гарсныг Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	3,273.9			1	3,273.9							
Баянзүрх дүүрэгт байрлах ажилчдын орон сууц нэртэй байшингийн 2008 онд эзэмших эрхийн гэрчилгээ авсан 203 м.кв, нэгж талбарын 1331401420 дугаартай газрыг яамны данс бүртгэлд тусгаагүй, тус барилга, газрыг ашиглах боломжгүй хэмжээнд хүрсэн байна.	1	44,655.6			1	44,655.6							

Татварын e-tax цахим системд тус яамны 4,849.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн өртэй гарсан бөгөөд газрын төлбөрийн ногдол гарсан Булган, Ховд, Төв аймгуудад байгаа газрын мэдээлэл тодорхойгүй, татварын алба, газрын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	4,849.0			1	4,849.0						
БНСУ-ын Хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлж байгаа KAPEX төслийн хүрээнд 2024 онд Сангийн яамнаас хоорондын тооцоогоор буцаан авсан Зөвлөх үйлчилгээний 6 ажлын 84,300.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөлгөөнд тусгаагүйгээр сонгон шалгаруулалт зарлаж, нэр бүхийн 3 байгууллагад гэрээний үндсэн дээр 12.25 нд нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжилт олгосон байна.	1	84,300.0			1	84,300.0						
ХХААХҮС-ын 2024.12.04-ний өдрийн А/688 дугаар тушаалаар балансаас балансад шилжүүлсэн Хүнсний ногооны үрийн хөнгөлөлтийг Аймаг, нийслэлд хуваарилахдаа бодит тооцоо судалгаанд үндэслэн хуваарилаагүйн улмаас 26,890.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.	1	-					1	-				
ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудыг Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэх шийдвэр гарсан ч тайлант	1	266,748.2					1	266,748.3				

хугацаанд 3Г-ын 9 дүгээр байрны ашиглалтын зардалд 266,748.2 мянган төгрөгийн байр ашиглалтын зардал төлсөн байна.												
Баянзүрх дүүргийн 12-р хороонд байрлах, 4563м.кв, 1331401299 нэгж талбарын дугаар бүхий, Хөдөө аж ахуйн машин, механизмын хашаа граж нэртэй эзэмших эрхтэй газрын гэрээг 2025 онд сунгасан боловч, гэрчилгээ, гэрээ байхгүй, балансад бүртгэлгүй, e-gazag цахим системд тус яамны нэр дээр байна.	1	-					1	-				
БЗД-ийн 3-р хороонд байрлах 1330100010 нэгж талбарын дугаартай, 975 м.кв тус яамны дансанд бүртгэлтэй газар дээр БШУЯамны УТХО-аар 2021 онд цэцэрлэг баригдаж, 979,348.8 мянган төгрөгийн 59-р цэцэрлэг байршиж байна. Тус газрын төлбөрт ХХААХҮЯам 2025 онд 409.5 мянган төгрөг газрын төлбөрт төлж байна.	1	409.5					1	409.5				
Хан-Уул дүүрэгт байрлах 1781001787 тоот нэгж талбарын дугаартай, 3398 м.кв, тус байгууллагын нэр дээрх "Үйлчилгээний орон сууц"-ны зориулалттай эзэмших эрхийн газрын гэрчилгээг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/682 тоот захирамжаар 15 жилийн хугацаатай сунгуулсан боловч гэрээг байгуулж баталгаажуулаагүй, газрын төлбөрт 2025 онд 13,048.3 мянган төгрөг төлсөн байна.	1	13,048.3					1	13,048.3				

<p>МУЗГ-ын 2013 оны "Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай" 250 дугаар тогтоол гарч 23,000,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2013 онд багтаан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгохыг Хөдөлмөрийн сайдад зөвшөөрсүгэй гэсэн шийдвэр гарсан.</p> <p>2013.07.16-ний өдрийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 23,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг /ХЭДС-аас 17,000,000.0 мянган төгрөг, ЖДҮХС-аас 6,000,000.0 мянган төгрөг/ Сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдэд олгох шийдвэр гарч, зээл, зээлийн хүүг эргэн төвлөрүүлэх, зээлийн эрсдэлийг ҮХААЯ бүрэн хариуцна гэж тус гэрээнд тусгасан байна. Гэрээний хүрээнд зээл авсан гэх компаниудаас шүүхийн шийдвэрээр зээлийн эргэн төлөлтөд орж ирсэн 1,180,143.6 мянган төгрөгийг ХЭДСанд тооцоо нийлсэн актгүйгээр төвлөрүүлсэн, тус гэрээнд заасан хамтарсан хяналтын зөвлөл хяналтаа хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.</p>	1	-			5	157,278.5	6	280,206.1	-	-	-	-
Дүн	11	437,484.6	-	-	5	157,278.5	6	280,206.1	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 28/A0161027

Улаанбаатар хот

САГ - 2026/276/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд найрамдах Солонгос Улсын Хөдөөгийн эдийн засгийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлж байгаа KAPEX төслийн хүрээнд 2024 онд Сангийн яамнаас хоорондын тооцоогоор буцаан авсан Зөвлөх үйлчилгээний ажлын 84,300,000.00 /Наян дөрвөн сая гурван зуун/ төгрөгийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүйгээр сонгон шалгаруулалт зарлаж, нэр бүхий 3 байгууллагад гэрээний үндсэн дээр 12 дугаар сарын 25-нд нэмэлт санхүүжилтийн данснаас санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар "Журам шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй ажлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Ахлах нягтлан бодогч (О.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-2.Docx

1526180075



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 29/A0161027

Улаанбаатар хот

САГ-2026/276/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны балансад бүртгэлгүй 9 тээврийн хэрэгслийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 3,273,938.00 /Гурван сая хоёр зуун далан гурван мянга есөн зуун гучин найман/ төгрөгийн ногдол гарсныг Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Тээврийн хэрэгслийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Ахлах нягтлан бодогч (О.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.БАТЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 30/А0161027

Улаанбаатар хот

САГ-2026/276/КА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дархан-Уул аймгаас Улаанбаатар хотод Улсын Их Хурлын чуулган болон Засгийн газрын хуралдаанд оролцох талаар нэг тушаалаар 20,200,000.00 /Хорин сая хоёр зуун мянган/ төгрөгийн дотоод томилолтын зардал гаргасан бөгөөд томилолтын тооцоо бодсон баримтгүй, илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйл 20.1.1-т "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод албан томилолтын зардлын тайлан, илтгэх хуудас чанартай бичиж хэвшээгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Ахлах нягтлан бодогч (О.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.БАТЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 31/АД161027

Улаанбаатар хот

САГ-2026/276/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны баланст бүртгэлтэй 44,655,600.00 /Дөчин дөрвөн сая зургаан зуун тавин таван мянга зургаан зуу/ төгрөгийн үнэтэй Баянзүрх дүүргийн 12 дугаар хороонд байрлах ажилчдын орон сууц нэртэй байшингийн /1 давхар, балгас болсон/ 2008 онд эзэмших эрхийн гэрчилгээ авсан 203 м.кв, бүхий нэгж талбарын 1331401420 дугаартай газрыг яамны данс бүртгэлд тусгаагүй, тус барилга, газрыг ашиглах боломжгүй хэмжээнд хүрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 14 дүгээр зүйлийн 14.2.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага," Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-ын 1 дэх хэсэгт "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус газрыг яамны хөрөнгийн дансанд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Ахлах нягтлан бодогч (О.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0124_SAG-2.Docx

1526180071



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 32/A0161027

Улаанбаатар хот

САГ-2026/276/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын ерөнхий газрын e-tax цахим системд тус яам 4,849,031.00 /Дөрвөн сая найман зуун дөчин есөн мянга гучин нэг/ төгрөгийн газрын төлбөрийн өртэй гарсан бөгөөд газрын төлбөрийн ногдол гарсан Булган, Ховд, Төв аймгуудад байгаа тус яамны нэр дээрх газрын мэдээллүүд тодорхойгүй, татварын алба, газрын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Булган, Ховд, Төв аймгуудад байгаа тус яамны нэр дээрх газрын мэдээллүүдийг тодорхой болгож, газрын төлбөрийн өрийг шийдвэрлэн, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Т.Жамбалцэрэн), Ахлах нягтлан бодогч (О.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

П.БАТЦЭЦЭГ